

**ТӨРӨӨС ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙГ АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ
БЭЛТГЭСЭН ТАЛААР ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2014 оны 10 дугаар
сарын 23-ны өдөр

Улаанбаатар
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын
гишүүн Б.Гарамгайбаатар**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

“Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын 2014 оны 7 дугаар сарын 01, 10 дугаар 02-ны өдрүүдийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлээд, төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Тус Байнгын хороо тогтоолын төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай асуудлыг 2014 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд тогтоолын төслийн 1 дэх заалтыг хасах болон 2 дахь заалтыг “Тавантолгой–Гашуунсухайт, Сайншанд-Ханги, Хөөт–Бичигт, Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын шинэ шугамыг 1435 мм-ийн царигтай, Арц суурь–Эрдэнэт, Тавантолгой–Сайншанд–Баруун-Урт–Хөөт–Чойбалсан, Хөөт–Нөмрөг чиглэлийн төмөр замын шинэ шугамыг 1520 мм-ийн царигтай барих ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/-т даалгасугай” гэж өөрчлөн найруулах саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхиор дэмжлээ.

Тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй болон найруулгын шинжтэй саналын томъёоллын жагсаалтыг Та бүхэнд тараасан.

Байнгын хорооны дарга, Ажлын хэсгийн ахлагчийн хувьд дээрх саналын томъёолол болон энэхүү тогтоолын төслийн талаар санал, бодлоо илэрхийлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Дээрх саналын томъёолол Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар дэмжигдэн батлагдсан тохиолдолд 2010 онд Улсын Их Хурлаас батлагдсан Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогод тусгагдаагүй шинэ маршрут бий болж байна. Тухайлбал, Сайншанд-Ханги чиглэл.


Түүнчлэн Төмөр замын талаарх бодлогын баримт бичигт тусгагдсан 1 дэх болон 2 дахь шатанд байгуулах хэд хэдэн чиглэлд өөрчлөлт орж байгаа тул Төрөөс төмөр замын талаарх бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулах зарчмаар асуудлыг нэг тийш нь шийдэх хэрэгтэй гэж үзэж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай асуудлаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавсанд баярлалаа.

АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ,
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Б.ГАРАМГАЙБААТАР

**“ТӨРӨӨС ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ” УЛСЫН ИХ
ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН
ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

Нэг.Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал

1.Тогтоолын төслийн 1 дэх заалтыг хасах.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Б.Гарамгайбаатар,
Ж.Батсуурь, Ц.Нямдорж, А.Тлейхан, Ц.Цолмон**

2.Тогтоолын төслийн 2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1/Тавантолгой–Гашуунсухайт, Сайншанд-Ханги, Хөөт–Бичигт,
Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын шинэ шугамыг 1435 мм-ийн
царигтай, Арц суурь–Эрдэнэт, Тавантолгой–Сайншанд–Баруун-Урт–Хөөт–
Чойбалсан, Хөөт–Нөмрөг чиглэлийн төмөр замын шинэ шугамыг 1520 мм-ийн
царигтай барих ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын
Засгийн газар /Н.Алтанхуяг/-т даалгасугай.”

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Б.Гарамгайбаатар,
Ж.Батсуурь, Ц.Нямдорж, А.Тлейхан, Ц.Цолмон**

Хоёр.Найруулгын шинжтэй саналын томьёолол

1.Тогтоолын төслийн тэмдэглэх хэсгийг “Монгол Улсын Их Хурлын 2010 оны
32 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах
бодлого”-ын 4.1.2 дахь заалт, 2012 оны 37 дугаар тогтоолоор баталсан “Монгол
Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн холбогдох
заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:”

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Б.Гарамгайбаатар,
Ж.Батсуурь, Ц.Нямдорж, А.Тлейхан, Ц.Цолмон**

Эдийн засгийн байнгын хороо